



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/27

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 23/14 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Түгийн овооны чиглэлийн авто замын ажлын зураг төслийн үнэ 20,000,000 (хорин сая) төгрөг, 6 дугаар багийн 24 дүгээр гудамжнаас А0301 улсын чанартай авто зам хүртэлх 0,9км авто замын зураг төслийн үнэ 27,000,000 (хорин долоон сая) төгрөг, баруун 4 замаас ТИС-ийн гүүр хүртэлх авто замын шинэчлэлтийн ажлын зураг төслийн үнэ 20,000,000 (хорин сая) төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдахаар төлөвлөгдсөн барилга байгууламжуудын гадна холбоожуулалтын техникийн нөхцөлийн зардалд 3,069,000 (гурван сая жаран есөн мянга) төгрөг, нийт 70,069,000 (далан сая жаран есөн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан зураг төсөл боловсруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0061

D:My Doc. Zahiramj. Zasag darga